



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2018 оны 01 сарын 09 өдөр

Дугаар A/04

Даланзадгад


**Жирэмслэлтээс сэргийлэх эм хэрэгсэл хуваарилах
тухай**

Өмнөговь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 11 сарын 28-ны өдрийн “Эх хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөр батлах тухай” 53 дугаар тогтоолын 2 дугаар зорилт, Аймгийн Засаг даргын 2017 оны 12 сарын 20-ны өдрийн “Гэрээ байгуулж, ажил гүйцэтгүүлэх тухай” А/1438 тоот захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Эх хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа жирэмслэлтээс сэргийлэх эм хэрэгслийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хуваарилагдсан эм хэрэгслийг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгаанд үндэслэн зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд хэрэглүүлэх, шаардлагатай тохиолдолд тухайн сумыг хариуцсан эх барих эмэгтэйчүүдийн их эмчийн зөвлөгөө, тусламж үйлчилгээг авч, тайланг хагас бүтэн жилээр гаргаж ажиллахыг Цогтцэций, Ханбогд сумын Сум дундын эмнэлэг, Гурвантэс, Номгон сумын Эрүүл мэндийн төв, Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг ЭТҮХ-ийн дарга /Ж.Отгонбайгал/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ӨНӨРЖАРГАЛ



Эрүүл мэндийн газрын 2018 оны 01 сарын
09 өдрийн А/Б/Г тоот тушаалын хавсралт



"ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД" хөтөлбөрийн хүрээнд нийлүүлсэн эм хэрэгслийн хуваарь

№	Эмийн нэр тун хэмжээ	Серийн дугаар	Баталгаат хугацаа	Үйлдвэрлэсэн улс, байгууллага	Нэгжийн үнэ	Сумдын нэрс, хуваарь					Нийт тоо	Нийт үнэ
						Цогтцэций сум	Ханбогд сум	Гурвантэс сум	Номгон сум	Энхийн хүслэн ӨЭМТ		
1	Этинилэстрадиол +левоноргестрол 30мкг+150мкг +7 төмрийн шахмал	FE677003	2022-04	Энэтхэг - Mylan	3,000	40	30	30	30	50	180	540,000
2	Левоноргестрол 0,75мг №2	LD712	2022-03	Энэтхэг - Mylan	3,200	13	12	5	5	15	50	160,000
3	Бэлгэвч №90	16N3746	2021-11	Энэтхэг - Mylan	8,100	64	64	48	48	76	300	2,430,000
4	Охидын ерөндөг	UE023	2021-09	Энэтхэг - Mylan	5,500	20	20	15	5	40	100	550,000
5	Ерөндөг	AE-177	2022-03	Энэтхэг - Mylan	1,500	20	20	15	10	35	100	150,000
6	Жирэмснээс хамгаалах суулгац	YZ201707 02	2021-07	Энэтхэг - Mylan	31,000	13	12	10	0	15	50	1,550,000
Нийт дүн												5,380,000

Хуваарь гаргасан: *Б. Мэндбаяр* Эмийн бодлогын мэргэжилтэн Б.Мэндбаяр